



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 06 сарын 06 өдөр

Дугаар 267

Улаанбаатар хот

Чингис хаан судлалыг хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсын Кэмбрижийн их сургуулийн Нийгмийн антропологийн тэнхимиин Монгол ба Өвөр Ази судлалын төвтэй хамтран Чингис хаан судлал чиглэлээр хийгдэх судалгааны ажилд тэтгэлэг олгох арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Соёлын сайд Ч.Номин, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан нарт даалгасугай.

2. Судалгааны ажлын тэтгэлгийн хэмжээг жилд 100,000 (нэг зуун мянга) ам.доллартой тэнцэх хэмжээтэй, нийт 5 жилийн хугацаанд олгохоор тооцож, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг жил бүрийн төсвийн төсөлдөө тусгаж байхыг Соёлын сайд Ч.Номинд үүрэг болгосугай.

3. Судалгааны ажлын тэтгэлэгт энэ онд шаардагдах эх үүсвэрийг 2024 оны батлагдсан төсвийн багцдаа багтаан зохицуулж шийдвэрлэхийг Соёлын сайд Ч.Номинд даалгасугай.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

СОЁЛЫН САЙД

Ч.НОМИН

ШТА1206 9023100394 5498449